

**ӨМГӨӨЛЛИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ЗАРИМ ЗААЛТЫГ ХҮЧИНГҮЙ
БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ
ҮНЭЛСЭН ТАЙЛАН**

№	Шалгуур үзүүлэлт	Тохирох шалгах хэрэгсэл
1	Зорилгод хүрэх байдал	<p><i>Хуулийн төслийн зорилго:</i></p> <p>Аливаа хуульч өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх эрхийн шалгалтад хууль бус хязгаарлалтаас ангид байж, бүртгүүлэх боломжийг олгох, хүний эрх зөрчихгүй байх, хуульчийн эрх зүйн байдлыг дордуулсан, түүний ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох эрхийг хангах</p> <p><i>Төсөлд тусгагдсан зохицуулалт нь хуулийн төслийн зорилгод нийцэж буй эсэх:</i></p> <p>Хуулийн төслийн 1 дүгээр зүйлд “Өмгөөллийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.6.3 дахь заалтыг бүхэлд нь хүчингүй болсонд тооцсугай” гэж заасан бөгөөд ингэснээр хуульч өмгөөлөлийн эрхийн шалгалтад оролцохоор бүртгүүлэхдээ Өмгөөллийн хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12. /хууль зүйн чиглэлээр багшлах, эрдэм шинжилгээ, судалгааны ажил хийх, өмгөөллийн хуулийн этгээд, мэргэжлийн холбоо, түүний хороодын чиг үүрэгт хамаарахаас бусад ажил, албан тушаал хавсран эрхлэх/, 15.1.13 /улс төрийн нам, түүний харьяа, салбар, бүтцийн нэгжид орон тооны ажил, албан тушаал хавсран эрхлэх/-т заасан албан тушаалаас чөлөөлөгдсөн байх үүрэг хүлээхгүй болно.</p>
2	Практикт хэрэгжих боломж	Практикт хэрэгжихэд ямар нэг хүндрэл үүсэхгүй, сөрөг үр дагавар гарахгүй
3	Ойлгомжтой байдал	Тус хуулийн төслийг боловсруулах шатанд Монголын өмгөөлөгчдийн холбоо, бусад этгээдээс холбогдох саналыг авсан, мөн Хууль тогтоомжийн тухай хууль, “Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлал”-д заасан журмын хүрээнд төслийг боловсруулсан.

4	Хүээн зөвшөөрөгдөх байдал	Хуулийн төсөлд тодорхой этгээдэд үүрэг хүлээлгэсэн, хуулийн этгээдэд ачаалал, хүндрэл үүсгэх, эсхүл төрийн байгууллагад шинэ бүтэц бий болгох, чиг үүрэг нэмэх зэрэг зохицуулалт тусгаагүй тул энэ шалгах хэрэгслийг ашиглахгүй.
5	Зардал	Иргэн, хуулийн этгээд, улсын төсөвт аливаа зардал үүсэхгүй буюу ямар ч дарамт байхгүй тул энэ шалгах хэрэгслийг ашиглахгүй.
6	Харилцан уялдаа	Хуулийн төсөл "Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлал-ын 4 дүгээр зүйлийн 4.10-т заасан журмын шаардлагыг хангана.

ЗӨВЛӨМЖ:

Өмгөөллийн тухай хуулийн зарим заалтыг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээ эерэг гарч байна. Хуулийн төсөл батлагдсан тохиолдолд зорилгодоо хүрэх байдал нь эерэг, тухайн зохицуулалтыг дагаж мөрдөх, хэрэгжүүлэх боломжтой.

Хуулийн төслийг Монголын өмгөөлөгчдийн холбоо хэрэглэх бөгөөд тус байгууллага хүлээн зөвшөөрч байгаа тул хуулийн төслийг хэвээр үлдээх нь зүйтэй.

Уг хуулийн төслийн үр нөлөөг үнэлсэн тайлангаар хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон иргэн, хуулийн этгээд, улсын төсөвт аливаа зардал үүсэхгүй гэж дүнгэсэн тул зардлын тооцоо хийх шаардлагагүй байна.